

“НЭГ ЭРҮҮЛ МЭНД” ЗОРИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД МАЛЧИН ТАНЫ ОРОЛЦОО

Танай аж ахуйд бичил биетний эсрэг эмийг хэрхэн хэрэглэж байгаа нь зөвхөн танай мал, сүргийн эрүүл мэндэд төдийгүй хүний эрүүл мэнд, ургамлын эрүүл мэнд болон байгаль орчинд нөлөөлдөг гэдгийг Та мэдэх үү?

Бүх зүйл хоорондоо уялдаа, холбоотой өнөөгийн Дэлхий ертөнцөд таны гаргаж буй шийдвэрүүд нь бичил биетний тэсвэржилт (ББТ)-ийг бууруулахад хувь нэмэр болж, улмаар хүн бүрийн эрүүл мэндэд эерэг нөлөө үзүүлэх боломжтой.

Малын өсөлтийг нэмэгдүүлэх зорилгоор бичил биетний эсрэг эм хэрэглэдэг зуршлаас яагаад татгалзах хэрэгтэй вэ?

Учир нь бичил биетний эсрэг эмийг зөвхөн танай малын эрүүл мэнд, тавлаг байдалд асуудал үүссэн үед л хэрэглэх ёстой. Эрүүл малын ашиг шим, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор бичил биетний эсрэг эм хэрэглэх нь мал эмнэлгийн эмчилгээний хэрэглээ биш юм.

Түүнчлэн эрх бүхий байгууллагууд малын болон хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөлд нарийвчилсан үнэлгээ хийсний дараа л энэхүү хэрэглээг зохистой хэрэглээ гэж үзэж болно.

Малын ашиг шимийг нэмэгдүүлэхийн тулд чанартай тэжээл, цэвэр ундны цэвэр усаар хангах зэрэг олон арга байдаг. Эдгээр нэмэлт арга хэмжээ нь бичил биетний тэсвэржилт (ББТ) үүсэх эрсдэлийг нэмэгдүүлэхгүйгээр малын эрүүл мэнд болон хүний эрүүл мэндийг хамгаалахад тусална.

